

37 Шинэ Иерусалим

²⁵Иерусалимыг сэргээн барьж босгохоор зарлиг гарах цагаас эхлээд Жонон Мессиа ирэх хүртэл долоон долоон хоног болон жаран хоёр долоон хоног байх болно гэдгийг чи мэдэж ухаар. Зовлонгийн цагт ч гэсэн Иерусалим хэрэм, далантайгаа сэргээн босгогдоно. (Даниел 9:25 АБ 2004)

¹⁸ЭЗЭН ингэж айлдаж байна.“Үзэгтүн, Би Иаковын айхнуудын сайн сайхныг сэргээн, түүний амьдардаг газруудад өршөөл үзүүлнэ.Хот өөрийн балгас дээр дахин баригдаж, ордон өөрийн зөв газартаа босох болно. (Иеремиа 30:18 АБ 2004)

¹⁹Тэднээс талархлууд болон баярлан цэнгэдэг хүмүүсийн дуу хоолой гарна. Би тэднийг олшруулж, тэд цөөрөхгүй. Би бас тэднийг хүндэтгэж, тэд өчүүхэн байхаа болино. (Иеремиа 30:19 АБ 2004)

³ЭЗЭН ийн айлдаж байна. “Би Сион уруу эргэж, Иерусалимын дунд оршино. Тэгээд Иерусалим нь Үнэний Хот хэмээн дуудагдаж, түмэн цэргийн ЭЗЭНий уул нь Ариун Уул хэмээн дуудагдах болно”. (Зехариа 8:3 АБ 2004)

¹¹“Салхинд туугдсан, тайвширшгүй, зовсон нэгэн ээ. Үзэгтүн. Би чамайг оюугаар барьж, чиний суурийг биндэрьяагаар тавина. ¹²Цаашилбал, Би чиний цонхнуудыг бадмааргаар, дааман хаалгуудыг болроор хийж, хана чинь бүхэлдээ үнэт чулуу болно. (Исаиа 54:11-12 АБ 2004)

⁴⁰Эзэн БУРХАН тунхаглаж байна. “Учир нь Миний ариун уул, Израилийн өндөр уулан дээр, тэнд Израилийн хамаг гэр, тэд бүгд тэр газарт Надад үйлчлэх болно. Тэнд Би тэднийг хүлээн авч, та нарын бүх ариун юмсын хамт хандив болон бэлгүүдийн чинь хамгийн шилмэлийг хайх болно. ⁴¹Та нарыг ард түмнүүдийн дундаас гаргаж, тараагдсан газруудаас чинь цуглуулах цагт Би та нарыг тайвшруулах тааламжит үнэр мэт хүлээж авна. Үндэстнүүдийн нүдэн дээр та нарын дунд

Би Өөрийгөө ариун гэдгээ нотолно. (Езекиел 20:40-41 АБ 2004)

⁶Түмэн цэргийн ЭЗЭН ингэж айлдаж байна. “Тун удахгүй дахин нэг удаа Би тэнгэр ба газар, далай ба хуурай газрыг сэгсрэх гэж байна. ⁷Би бүх үндэстнийг сэгсэрнэ. Тэд бүх үндэстний эд баялагтай хамт ирнэ. Би энэ өргөөг цог жавхлангаар дүүргэх болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. ⁸“Мөнгө Минийх, алт Минийх” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаж байна. ⁹“Энэ өргөөний хожмын сүр жавхлан, урьдынхаасаа илүү агуу байх болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаад “Энэ газарт Би амар тайвныг өгнө” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаж байна гэв. (Хаггай 2:6-9 АБ 2004)

¹⁶Иймээс ЭЗЭН айлдаж байна. “Би өрөвдөн Иерусалим уруу эргэж ирсэн учир Миний өргөө тэнд босгогдох болно” гээд “Хэмжүүр Иерусалимын дээгүүр татагдах болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаж байна”. (Зехариа 1:16 АБ 2004)

⁹Сүүлчийн долоон гамшгаар дүүрэн долоон аягатай долоон тэнгэр элчийн нэг нь ирээд надтай ярилцан -Нааш ир. Би чамд Хурганы эхнэр болох сүйт бүсгүйг үзүүлэе гэв. ¹⁰Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр Сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ. ¹¹Түүнд Бурханы алдар нь байлаа. Гялбаа нь үнэт чулуу мэт бөгөөд талст шиг тунгалаг хас чулуу мэт байв. ¹²Тэр нь асар том өндөр хэрэмтэй бөгөөд арван хоёр хаалгатай байлаа. Хаалганууд дээр нь арван хоёр тэнгэр элч байлаа. Тэдгээрийн дээр Израилийн хөвгүүдийн арван хоёр овгийн нэрс бичигдсэн байв. ¹³Зүүн талд нь гурван хаалга, хойд талд нь гурван хаалга, өмнө талд нь гурван хаалга, баруун талд нь гурван хаалга байх аж. ¹⁴Хотын хэрэм нь арван хоёр суурьтай агаад тэдгээрийн дээр Хурганы арван хоёр элчийн арван хоёр нэрс байлаа. ¹⁵Надтай ярьсан тэнгэр элчид хот болон хаалгануудыг, мөн хэрмийг нь хэмжих алтан шугам байв. ¹⁶Хот нь дөрвөлжин бөгөөд урт нь өргөнтэйгөө адил аж. Тэнгэр элч хотыг шугамаараа хэмжихэд урт, өргөн,

өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байлаа.¹⁷Тэр хотын хэрмийг хэмжихэд, хүний хэмжээс ба мөн тэнгэр элчийн хэмжээсээр зуун дөчин дөрвөн пехус болов.¹⁸Хэрмийг хас чулуугаар хийсэн бөгөөд хот нь тунгалаг шил мэт шижиур алт ажээ.¹⁹Хотын хэрмийн сууриуд нь төрөл бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэгджээ. Эхний суурь нь хас, хоёр дахь нь индранил, гурав дахь нь гартаам, дөрөв дэх нь маргад эрдэнэ,²⁰тав дахь нь мамагартаам, зургаа дахь нь нал, долоо дахь нь хашиг, найм дахь нь биндэрьяа, ес дэх нь молор, арав дахь нь мана, арван нэг дэх нь оюу, арван хоёр дахь нь ягаан болор байв.²¹Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэг бүр нь нэгэн цул сувд байсан бөгөөд хотын гудамж нь тунгалаг шил мэт шижиур алт байв. (Илчлэлт 21:9-21 АБ 2004)

¹Тэр надад Бурханы болон Хурганы сэнтийнээс гарах талст мэт гялалзсан амийн усны голыг үзүүлсэн нь ²гудамжных нь төвд байв. Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байв.³Тэнд цаашид ямар ч хараал байхгүй болно. Мөн Бурхан ба Хурганы сэнтий түүний дотор байж, боолууд нь Түүнд үйлчилнэ.⁴Тэд Түүний царайг харна. Мөн Түүний нэр тэдний духан дээр байх болно.⁵Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд дэнлүүний гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй болно. Учир нь Эзэн Бурхан тэднийг гийгүүлнэ. Тэгээд тэд үеийн үед хаанчлах болно. (Илчлэлт 22:1-5 АБ 2004)

[] Бурханы дайсан яагаад Иерусалимыг хүсдэг болон тэрхүү дайсан нь хэн болохыг хэн болохыг та мэдэх үү?

[] Бурханд бидний мөнгө, материаллаг зүйл хэрэггүй байдаг Тэрээр яагаад өргөл шаарддагийг мэдэх үү?

[] Өөрийн өргөөг алдраар дүүргэхээс өмнө Бурхан яагаад тэнгэр, газрыг сэгсрэхийг та мэдэх үү?

[] Амийн голоос хэн ууж болохыг та мэдэх үү?

37.1 Бурханы орших газар

²⁷Миний орших газар бас тэдэнтэй хамт байх болно. Би тэдний Бурхан болж, тэд Миний ард түмэн болно. (Езекиел 37:27 АБ 2004)

²²Би хотод ямар ч сүм харсангүй. Учир нь Төгс хүчит Эзэн Бурхан ба Хурга бол тэндхийн сүм юм. ²³Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа. ²⁴Үндэстнүүд тэр гэрлээр нь алхацгааж, газрын хаад тийшээ алдраа авчирна. ²⁵Хотын хаалганууд өдөр хэзээ ч хаагдахгүй. Учир нь тэнд шөнө гэж байхгүй. ²⁶Тэд үндэстнүүдийн алдар, хүндлэлийг тийшээ авч ирнэ. ²⁷Ямар ч бузар юм болон жигшүүрт зүйл үйлддэг болон худал ярьдаг хэн ч хэзээ ч тийшээ орохгүй. Харин зөвхөн Хурганы амийн номд нэрс нь бичигдсэн хүмүүс л орох ажгуу. (Илчлэлт 21:22-27 АБ 2004)

⁹Сэрэгтүн, сэрэгтүн! ЭЗЭНий мутар минь! Хүчээ ав! Өнийн өдрүүд, эрт урьдын үеүдийнх шигээ сэрэгтүн. Рахабыг хэсэгчин тастаж, лууг цоо хатгасан нь Та бус уу? ¹⁰Далай тэнгис, их гүний усыг хатаан, аврагдагсдыг гатлуулахын тулд тэнгисийн гүнийг зам болгосон нь Та бус уу? ¹¹ЭЗЭНий зольсон хүмүүс буцаж, баяртайгаар дуулан Сион уруу ирнэ. Тэдний магнай дээр мөнхийн баяр хөөр байна. Тэд зугаа цэнгэл, баяр хөөртэй байх бөгөөд гашуудах, санаа алдах нь зугтан одно. (Исаиа 5:9-11 АБ 2004)

⁶Иерусалим аа, Би чиний хэрмэн дээр манаач нарыг тавив. Тэд бүх л өдөржин, бүх л шөнөжин хэзээ ч дуугаа хураахгүй. ЭЗЭНийг дурсагч аа, бүү амрагтун. ⁷Тэр Иерусалимыг босгож, байгуулж газрын магтаал болгох хүртэл нь Түүнд бүү амралт өгөгтүн. (Исаиа 62:6-7 АБ 2004)

[] "Түүний оршихуй нь тэдэнтэй хамт байх болно " гэдгийн утга учрыг та мэдэх үү?

[] Өөрийнхөө дайсны эсрэг хэрхэн тунхаглахаа мэдэх үү?

37.3 Амийн мод ба амийн ус

Тэр надад Бурханы болон Хурганы сэнтийнээс гарах талст мэт гялалзсан амийн усны голыг үзүүлсэн нь ²гудамжных нь төвд байв. Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байв.

³Тэнд цаашид ямар ч хараал байхгүй болно. Мөн Бурхан ба Хурганы сэнтий түүний дотор байж, боолууд нь Түүнд үйлчилнэ. ⁴Тэд Түүний царайг харна. Мөн Түүний нэр тэдний духан дээр байх болно. ⁵Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд дэнлүүний гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй болно. Учир нь Эзэн Бурхан тэднийг гийгүүлнэ. Тэгээд тэд үеийн үед хаанчлах болно. (Илчлэлт 22:1-5 АБ 2004)

[] Түүний хаанчлал тэнгэрт шигээ газар дээр ирэх үед Бурхан Өөрийн хүүхдүүдийн төлөө юу бэлдсэнийг та харж байна уу?

37.4 Бузартаагүй нэгэнүүд нь орох болно

¹Сэрэгтүн, сэрэгтүн. Сион оо. Өөрийгөө хүч чадлаар хувцаслагтун. Ариун хот Иерусалим аа. Үзэсгэлэнт хувцсаа өмс. Учир нь цаашид хөвч хөндүүлээгүй болон бузар нь чам уруу ирэхгүй. ²Шороогоо гөвөгтүн. Босоцгоо. Олзлогдсон Иерусалим аа. Сионы олзлогдсон охин оо. Хүзүүнийхээ гинжийг тайлагтун. (Исаиа 52:1-2 АБ 2004)

[] Найман ерөөл бол дэлхий дээр таныг байхад л өгдөг боломж гэдгийг та мэдэх үү?

37.5 Гол мэт энх тайван

“Иерусалимыг хайрлагчид бүгдээрээ түүнтэй баясан цэнгэгтүн. Түүний төлөө гашуудагсад бүгдээрээ түүнтэй хамт агуу ихээр баясан жаргагтун. ¹¹Учир нь чи түүний тайвшруулагч мээмнээс хөхөж цадна. Чи хөхөж элбэг хангалуун энгэрт нь баярлана”. ¹²Учир нь ЭЗЭН үүнийг

айлдаж байна. “Үзэгтүн. Би түүнд гол мэт энх амгаланг өгч, үндэстнүүдийн алдрыг үерийн урсгал мэт болгоно. Та нарыг тэжээж, гар дээрээ өргөн, өвдөг дээрээ энхрийлнэ. ¹³Эх нь хүүгээ тайвшруулдаг шиг Би та нарыг тайвшруулна. Та нар Иерусалимд тайвшрах болно”. ¹⁴Үүнийг үзээд та нарын зүрх баясаж, та нарын яс шинэхэн өвс мэт цэцэглэнэ. ЭЗЭНий мутар боолууддаа мэдэгдэнэ. Харин Тэр дайснуудаа зэвүүцнэ. (Исаиа 66:10-14 АБ 2004)

[] Та Иерусалимын төлөө гашууддаг уу?

37.6 Шинэ сүм

37.6.1 Тахилч

¹⁴Би тахилч нарын сэтгэлийг элбэг дэлбэгээр дүүргэж, Миний ард түмэн Миний сайн байдалд хангалуун байх болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Иеремиа 31:14 АБ 2004)

³⁵Гэвч Миний зүрх болон Миний сэтгэлд байгаа зүйлсийн дагуу үйлдэх үнэнч тахилчийг Би Өөрийнхөө төлөө өргөмжилнө. Би түүнд бат бэх гэрийг барьж өгнө. Тэр үргэлж Миний тосолсон хүний өмнө алхах болно. (1 Самуел 2:35 АБ 2004)

²¹“Мөн Би тэдний заримыг нь тахилч болон леви хүн болгохоор авна” гэж ЭЗЭН айлдав. (Исаиа 66:21 АБ 2004)

¹Иуда, Иерусалимын талаар үзсэн Амозын хүү Исаиагийн үг.
²Эцсийн өдрүүдэд ЭЗЭНий өргөөний уул нь уулсын тэргүүнээр тохоогдон, толгодын дээгүүр өргөгдөнө. Бүх үндэстнүүд түүн уруу цутган ирнэ. ³Олон ард түмнүүд ирээд “Ирцгээ, ЭЗЭНий уул уруу, Иаковын Бурханы өргөө уруу явцгаая. Тийнхүү Тэрээр бидэнд Өөрийн замыг зааж, бид Түүний жимээр алхах юм” гэгцгээнэ. Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭНий үг Иерусалимаас гарна.
⁴Тэр үндэстнүүдийн хоорондхыг шүүж, олон ард түмнүүдэд шийдвэр гаргах болно. Тэд илдээ анжисны хошуу, жадаа хадуур болгон давтана. Үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй бөгөөд дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй. (Исаиа 2:1-4 АБ 2004)

⁹Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Зүрхэндээ хөвч хөндүүлээгүй, махан биедээ ч хөвч хөндүүлээгүй ямар ч харь хүн, Израилийн хөвгүүдийн дунд буй бүх харь хүнээс нэг нь ч Миний ариун газарт орж болохгүй. (Езекиел 44:9 АБ 2004)

⁷Кедарын бүх хонин сүрэг чам дээр цугларч, Небаиотын хуцнууд чамд үйлчилнэ. Тэд Миний тахилын ширээнд тааламжтайгаар өргөгдөн, Би Өөрийн сүр жавхлантай гэрийг алдаршуулна. (Исаиа 60:7 АБ 2004)

⁷Би Өөрийн ариун ууланд аваачин, Өөрийн залбирлын өргөөнд тэднийг баяр хөөртэй болгоно. Тэдний шатаалт тахил, өргөлүүд нь Миний тахилын ширээн дээр тавигдана. Учир нь Миний өргөө бүх ард түмний залбирлын өргөө гэж нэрлэгдэнэ”. (Исаиа 56:7 АБ 2004)

“Энэ өргөөний хожмын сүр жавхлан, урьдынхаасаа илүү агуу байх болно” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаад “Энэ газарт Би амар тайвныг өгнө” гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаж байна гэв. (Хаггай 2:9 АБ 2004)

[] "Хүлээн зөвшөөрөгдсөн залбирал ба өргөл" гэдэг нь юу болохыг та мэдэх үү?

[] Залбирлын өргөө гэж юу болохыг та мэдэх үү?

38.6.3 Иерусалимын ариун сүмийн суурь тавигдах

²⁴Чамайг эхийн хэвлийгээс гаргасан нэгэн, чиний Аврагч ЭЗЭН үүнийг айлдаж байна. “Би бүх юмсыг бүтээгч ЭЗЭН. Би Өөрөө тэнгэрийг сунгаж, дэлхийг ганцаараа дэлгэсэн. ²⁵Би хуурамч эш үзүүлэгчдийн тэмдгийг нурааж, төлөгчдийг мунхгууд болгож, мэргэдийн ухааныг устган, тэдний мэдлэгийг мунхаглал болгоно. ²⁶Тэр Өөрийн боолуудын үгийг баталж, элч нарынхаа зорилгыг гүйцэтгэнэ. Би Иерусалимд хандан “Чи оршин суугчидтай болно”, Иудагийн хотуудад “Та нарыг босгох болно” гэсэн. Нуранги балгаснуудыг нь Би дахин босгоно. ²⁷Би тэнгисийн усанд хандан “Хатагтун. Би та нарын голуудыг ширгээнэ” гэж айлдсан. ²⁸Би Корешт хандан “Тэр Миний хоньчин. Миний бүх хүслийг тэр гүйцэтгэнэ” гэв. Тэр Иерусалимд хандан “Чи

босгогдоно”, мөн сүмд хандан “Чиний суурь нь тавигдана” гэж айлдана”. (Исаиа 44:24-28 АБ 2004)

[] Бурхан таныг эхийн хэвлийд бүрэлдүүлсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Тэрхүү боолын хэлсэн үгийн дагуу болсны учрыг та мэдэх үү ?

[] Бурхан л тэнгэр, газар, тэдгээрт байгаа бүхнийг бүтээсэн гэдэгт итгэдэг үү ?

[] Зөвийг юу ойлгомжтой, баталгаатай болгодгийг та мэдэх үү?

37.6.4 Шинэ гэрээ

³¹ЭЗЭН тунхаглаж байна. “Үзэгтүн, Израилийн гэр болон Иудагийн гэртэй Би шинэ гэрээ хийх өдрүүд ирж байна. (Иеремиа 31:31 АБ 2004)

⁶⁰Гэсэн ч чиний залуу насны өдрүүдэд чамтай байгуулсан Өөрийн гэрээгээ Би санаж, чамтай мөнхийн гэрээг байгуулна. (Езекиел 16:60 АБ 2004)

⁶²Ийнхүү Би чамтай Өөрийн гэрээг байгуулах бөгөөд чи Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно. (Езекиел 16:62 АБ 2004)

²⁶Би тэдэнтэй энх тайвны гэрээг байгуулах болно. Энэ нь тэдэнтэй тогтоох мөнхийн гэрээ байх болно. (Езекиел 37:26 АБ 2004)

[] Энэхүү мөнхийн гэрээ нь болзолгүй гэдгийг та мэдэх үү?

37.7 Таныг хамгаалахаа амласан

37.7.1 Бүх дайснаас тань хамгаалах

²⁰Тэдний хүүхдүүд бас урьдынх шигээ байж, тэдний цуглаан Миний өмнө тогтоогдох болно. Би тэдний бүх дарлагчдыг шийтгэнэ. (Иеремиа 30:20 АБ 2004)

²²Хамгийн өчүүхэн нэгэн нь мянга болж, хамгийн бага нэг нь хүчирхэг үндэстэн болно. ЭЗЭН Би үүнийг тухайн цагт нь яаравчлах болно”. (Исаиа 60:22 АБ 2004)

⁶Тэр өдөр Би Иудагийн тэргүүлэгчдийг зэрэглэсэн модон дундах галт тогоо мэт, юүжилсэн тариан дундах галт бамбар мэт байлгана. Тэд баруун, зүүн гар дахь эргэн тойронд буй бүх ард түмнүүдийг түймэрдэх зуур Иерусалимын оршин суугчид төрөлх хотдоо дахин суурьшина. (Зехариа 12:6 АБ 2004)

¹⁰Би Өөрийн ард түмэн Израильд газар нутаг тогтоож, тэднийг тэнд суулгана. Тэд өөрсдийн газарт суун, дахин үймээн самуунд ч автахгүй, муу хүмүүс тэднийг урьдынх шиг зовоохоо ч болино. ¹¹Миний ард түмэн Израилийг удирдахыг Би шүүгчдэд тушаасан өдрөөс хойш Би чамайг хамаг дайснуудаас чинь хамгаалж, амраана. ЭЗЭН мөн чамд гэр бий болгохыг чамд мэдүүлж байна. (2 Самуел 7:10-11 АБ 2004)

Гэвч Би чамайг тэр өдөр аварна” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Чи өөрийн айдаг хүмүүсийн гарт өгөгдөхгүй. (Иеремиа 39:17 АБ 2004)

¹⁸Учир нь Би чамайг заавал аварч, чи илдэнд унахгүй. Харин чи Надад итгэсэн тул өөрийн амиа олз мэт авна” гэж ЭЗЭН тунхаглаж байна” гэж хэлээрэй” гэв. (Иеремиа 39:18 АБ 2004)

¹⁰“Хэрэв та нар үнэхээр энэ нутагт үлдвэл, Би та нарыг нураах биш, босгох бөгөөд та нарыг тастчин сугалах биш, тарин суулгах болно. Учир нь та нарт учруулсан гай гамшгийн талаар Би зөөлөн хандах болно(Иеремиа 42:10 АБ 2004)

²⁷“Харин, Миний зарц Иаков аа, чиний хувьд, бүү ай! Бүү зүрх алд, Израиль аа! Учир нь хараач, Би чамайг холоос, үр удмыг чинь тэдний олзлолын нутгаас аврах гэж байна. Иаков буцан ирж, айлган чичрүүлэх ямар ч хүнгүйгээр амар амгалан, аюулгүй байх болно. (Иеремиа 46:27 АБ 2004)

¹⁰Миний зарц Иаков аа, бүү ай” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Израиль аа, бүү зүрх алд. Учир нь харагтун, Би чамайг алсаас, чиний үр удмыг олзлогдсон нутгаас нь аварна. Иаков

буцан ирж, чимээгүй болон тайван байж, түүнийг хэн ч айлгахгүй. (Иеремиа 30:10 АБ 2004)

⁸Түмэн цэргийн ЭЗЭН ийн айлдаж байна. “Цог жавхлангийн дараа Тэр намайг, та нарыг дээрэмдсэн үндэстнүүдийн эсрэг илгээв. Учир нь та нарт хүрэгч нь Түүний мэлмийн цэ цгийд хүрдэг. (Зехариа 2:8 АБ 2004)

37.7.2 Хэн ч чамайг дахин ялахгүй

¹⁵Хэрэв хэн нэгэн нь чам уруу хэрцгийлэн халдвал, тэр нь Надаас биш юм. Чам уруу халдагч нь чамаас болж унана.

¹⁶Үзэгтүн, нүүрсний галыг хөөрөгдөн ашиглахын тулд зэвсэг хийдэг дархныг Би бүтээсэн. Би хөнөөхийн тулд сүйтгэгчийг бүтээв. ¹⁷Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг бүтэлтэй болохгүй.

Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүр яллагдана. Энэ бол ЭЗЭНий зарцуудын өв бөгөөд Надаас ирэх тэдний зөвтгөл юм” гэж ЭЗЭН зарлиг болгов. (Исаиа 54:15-17 АБ 2004)

37.7.3 БИ БОЛ хамгаалагч

²⁴Хүчтэй хүнээс олзыг нь авч, харгислагчийн хоригдлуудыг аварч чадах уу?” ²⁵Харин ЭЗЭН ингэж айлдаж байна. Хүчтэй хүнээс хоригдлуудыг нь булаан авч, харгислагчдаас олзыг нь аварна. Учир нь чамтай тэрсэлдэгч нэгэнтэй Би тэмцэлдэж, хөвгүүдийг чинь аврах болно.

²⁶Чамайг дарлагчдыг Би өөрсдийнх нь махаар хооллоно. Тэд өөрсдийнхөө цусыг амтат дарс мэт ууж, согтоно. ЭЗЭН Би бол чиний Аврагч, чиний Чөлөөлөгч, Иаковын хүчит Нэгэн гэдгийг бүх махан бие мэдэх болно”. (Исаиа 49:24-26 АБ 2004)

⁴Учир нь ЭЗЭН надад “Олон хоньчид нийлэн хашхирч, гуугалавч тэдний дуу чимээг үл хайхран, айхгүйгээр олзон дээрээ архирагч арслан, залуу арслан шиг түмэн цэргийн ЭЗЭН дайн хийхээр Сион уул болон толгодынх нь дээр бууж ирнэ.

⁵Элин халих шувууд мэт түмэн цэргийн ЭЗЭН Иерусалимыг хамгаална. Тэр хамгаална, чөлөөлнө. Тэр дээгүүр нь өнгөрнө, аварна” хэмээн айлдав. ⁶Израилийн хөвгүүд ээ, та нар хэнээс эрс нүүр буруулсан Түүн уруугаа буцагтун. ⁷Учир нь тэр өдөр өөрсдийн гараар нүгэл болгон үйлдсэн мөнгөн шүтээнүүд, алтан шүтээнүүдийг хүн бүр хаяна. (Исаиа 31:4-7 АБ 2004)

⁶Иерусалим аа, Би чиний хэрмэн дээр манаач нарыг тавив. Тэд бүх л өдөржин, бүх л шөнөжин хэзээ ч дуугаа хураахгүй. ЭЗЭНийг дурсагч аа, бүү амрагтун. ⁷Тэр Иерусалимыг босгож, байгуулж газрын магтаал болгох хүртэл нь үүнд бүү амралт өгөгтүн.

⁸ЭЗЭН Өөрийн баруун мутар, хүчит гараараа тангараглав. “Би чиний үр тариаг дахин хэзээ ч дайснуудад чинь хоол болгон өгөхгүй. Мөн чиний хөдөлмөрөөр бий болсон шинэ дарсыг харийн хөвгүүд уухгүй. ⁹Харин үр тариа хураагчид нь түүнийг идэж, ЭЗЭНийг магтана. Усан үзмийг хураагчид нь үүнийг Миний ариун газрын хашаан дотор ууна”. (Исаиа 62:6-9 АБ 2004)

37.7.4 Сонгогдсон Нэгэн

⁸“Харин миний боол Израиль аа! Миний сонгосон Иаков аа! Миний найз Абрахамын үр удам аа! ⁹Би чамайг дэлхийн хязгаараас авч, хамгийн алслагдсан хэсгээс дуудаж, чамд хэлсэн. “Чи Миний боол. Би чамайг сонгосон. Чамайг голоогүй. ¹⁰Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар бүү санаа зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална. Би заавал Өөрийн зөв баруун мутраар чамайг хамгаална”. ¹¹Үзэгтүн, чамд хилэгнэсэн бүхэн гутаагдаж, хүндлэгдэхгүй. Чамтай маргалдагчид юу ч биш болж, сөнөнө. ¹²Чамтай маргалдагчдыг чи эрэвч олохгүй. Чамтай дайтагчид юу ч биш болж, оршин тогтнохгүй. ¹³Учир нь Би бол чиний баруун гараас атгадаг чиний Бурхан ЭЗЭН билээ. Би чамд “Бүү ай. Би чамд тусална” гэж айлдаж байна.

¹⁴Бүү айгтун. Өт Иаков, Израилийн эрчүүд ээ. Би чамд тусална. Чиний Золигч бол Израилийн Ариун Нэгэн юм” гэж ЭЗЭН тунхаглаж байна. ¹⁵Үзэгтүн, Би чамайг хоёр давхар

үзүүртэй, шинэ, хурц лантуу болгоно. Чи уулсыг бутлан, нунтаглаж, толгодыг сүрэл мэт болгоно. ¹⁶Чи тэднийг шигшинэ. Салхи тэднийг хийсгэн, шуурга тэднийг тараан хаяна. Харин чи ЭЗЭНд баярлаж, Израилийн Ариун Нэгэнээр бахархах болно. (Исаиа 41:8 -16 АБ 2004)

37.7.5 Израилийн төлөө бусад үндэстнүүдийг цуглуулна

¹ЭЗЭН хаадын хуяг дуулгыг алдууруулж, өмнө нь хүмүүс захирагдахын тулд баруун гартаа барьсан, дааман хаалганууд нь үл хаагдахын тулд өмнө нь хаалгуудыг дэлгэсэн, Өөрийн тослогдсон Корешт хандаж, ²“Би чиний өмнө явж, уулсыг тэгшлэн, хүрэл хаалгыг эвдэж, төмөр хаалтуудыг тастана. ³Энэ бол чамайг нэрээр чинь дуудсан Израилийн Бурхан, ЭЗЭН Би гэдгийг чамд мэдүүлэхийн тулд Би чамд харанхуйн эрдэнэс, нууц газруудын нууцалсан эд баялгийг өгнө. ⁴Миний боол Иаков, Миний сонгосон Израилийн төлөө Би мөн чамайг нэрээр чинь дуудсан. Хэдийгээр чи Намайг танихгүй ч, Би чамд хүндэт цол өгнө. ⁵Би бол ЭЗЭН. Өөр байхгүй. Надаас өөр Бурхан байхгүй. Хэдийгээр чи Намайг танихгүй ч, Би чамайг хүчирхэгжүүлнэ. ⁶Тийнхүү Надаас өөр хэн ч байхгүй, Би бол ЭЗЭН, өөр байхгүй гэдгийг наран мандахаас наран шингэх зүг хүртэлх хүмүүс мэдэх болтугай! ⁷Би гэрлийг буй болгон, харанхуйг бүтээж, энх амгаланг тогтоон, гай гамшгийг ч бүтээж байна. Би бол энэ бүгдийг хийдэг ЭЗЭН мөн. (Исаиа 45:1-7 АБ 2004)

¹³Би түүнийг үнэн зөвийн дотор босгон, бүх замыг нь тэгшилнэ. Тэр ямар ч хөлс, шагналгүйгээр Миний хотыг барьж, Миний хоригдлуудыг чөлөөтэй явуулна” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдав. (Исаиа 45:13 АБ 2004)

²²Эзэн БУРХАН айлдаж байна. “Үзэгтүн, Би мутраа үндэстнүүд уруу өргөн, ард түмнүүдэд Өөрийн тугийг босгоно. Тэд чиний хөвгүүдийг энгэртээ, охидыг чинь мөрөн дээрээ авчирна. (Исаиа 49:22 АБ 2004)

[] Бурханыг танихгүй үндэстнүүд болон ард түмэн Түүний зорилгын төлөө байх болно гэдгийг та мэдэх үү?

[] Өөрийгөө ард түмнүүдийн дундах цорын ганц Бурхан гэдгээ хэрхэн харуулдгийг та мэдэх үү?

37.8. Таньд нигүүлсэнгүй байдаг

37.8.1 Өөрийн Сүнсийг чам дээр болон чиний үр удам дээр асгах болно

²⁹Би хойшид Өөрийн нүүрийг тэднээс нуухгүй. Учир нь Би Израилийн гэр дээр Өөрийн Сүнсийг асгах болно” гэж ЭЗЭН БУРХАН тунхаглаж байна. (Езекиел 39:29 АБ 2004)

²⁸Түүний дараа Би Өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана.

Та нарын хөвгүүд, охид эш үзүүлэн, өвгөд чинь зүүд зүүдэлж, залуус чинь үзэгдлүүд үзнэ. ²⁹Тэдгээр өдрүүдэд Би боолууд, шивэгчингүүд дээр ч Өөрийн Сүнсээ цутгана. ³⁰Би тэнгэр болон газарт гайхамшгт тэмдгийг үзүүлнэ. Тэр нь цус, гал ба утаан багананууд болой. (Иоел 2:28-30 АБ 2004)

³Учир нь Би ангамал хөрсөн дээр ус асгаж, хуурай газар дээр горхи урсгана. Би чиний үр ач нарын дээр Өөрийн Сүнсийг асгаж, хойч үед чинь Өөрийн ерөөлийг өгнө. (Исаиа 44:3 АБ 2004)

¹³Миний ард түмэн, Би та нарын булшнуудыг нээж, та нарыг булшнуудаас чинь гаргасан үед та нар Намайг ЭЗЭН мөн гэдгийг мэдэх болно. ¹⁴Би та нарын дотор Өөрийн Сүнсийг тавьж, та нар амилж, Би та нарыг төрөлх нутагт чинь суулгах болно. Тэгээд ЭЗЭН Би үүнийг айлдсан ба үүнийг бүтээснийг та нар мэдэх болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна”. (Езекиел 37:13-14 АБ 2004)

²⁰“Аврагч нь Сион уруу Иаков дотор гэм нүглээс эргэсэн хүмүүс уруу ирнэ” гэж ЭЗЭН тунхаглав. ²¹“Миний хувьд энэ бол тэдэнтэй байгуулах Миний гэрээ” хэмээн ЭЗЭН айлдаж байна. “Чиний дээр байгаа Миний Сүнс, чиний аманд тавьсан Миний үгс нь чиний амнаас ч, чиний хүүхдүүдийн амнаас ч, чиний хүүхдүүдийн үр удмын амнаас ч одооноос

эхлэн үүрд мөнх салахгүй” гэж ЭЗЭН айлдаж байна. (Исаиа 59:20-21 АБ 2004)

[] Мөнхийн амь бол хамгийн шилдэг бэлэг гэдгийг та мэдэх үү?

[] Бусад сайн сайхнаас илүү сүнсний сайн сайхныг дээгүрт тавьж байна уу?

37.8.2 Тэдний газар дээрх цөмөрхийнүүдийг сэргээн засварлах

¹¹Тэр өдөр Давидын нурж унасан бүхээгийг Би босгож, түүний цөмөрхийнүүдийг шаван битүүлнэ. Мөн Би түүний балгаснуудыг босгож, түүнийг эртний өдрүүдийнх шиг нь дахин байгуулна. ¹²Ингэснээр тэд Едомын үлдэгсдийг болон Миний нэрээр дуудагдах бүх үндэстнүүдийг өмчлөх юм” хэмээн үүнийг үйлдэгч ЭЗЭН тунхаглаж байна.

¹³ЭЗЭН тунхаглаж байна. “Харагтун, газар хагалагч нь хураагч хүнд, усан үзмийн худалдаачин үр таригч хүнд ойртох үед уулс амтат дарсыг дуслуулж, бүх толгод алга болох өдрүүд ирж байна. ¹⁴Би бас Миний ард түмэн болох Израилийн олзлогдогсдоос буцаан авчирч, тэд нуранги хотуудыг дахин босгон амьдрах болно. Тэд бас усан үзэм, үзмийн төгөл тарьж, дарсыг нь уун, цэцэрлэгүүдийг байгуулж, жимсийг нь идэх болно. ¹⁵Би бас тэднийг өөрсдийнх нь газар дээр тарина. Миний тэдэнд өгсөн газраас тэд дахин үндсээрээ таслагдахгүй” гэж чиний Бурхан ЭЗЭН айлдаж байна. (Амос 9:11-15 АБ 2004)

²⁶Тэр Өөрийн боолуудын үгийг баталж, элч нарынхаа зорилгыг гүйцэтгэнэ. Би Иерусалимд хандан “Чи оршин суугчидтай болно”, Иудагийн хотуудад “Та нарыг босгох болно” гэсэн. Нуранги балгаснуудыг нь Би дахин босгоно. (Исаиа 44:26 АБ 2004)

⁶Учир нь Би сайны төлөө Өөрийн мэлмийг тэдэн дээр тогтоох бөгөөд Би тэднийг энэ нутаг уруу дахин авчирна. Би тэднийг барьж босгох бөгөөд унагахгүй, тэднийг тарьж суулгах бөгөөд зулгааж тастахгүй. (Иеремиа 24:6 АБ 2004)

37.8.3 Хоёр дахин их хувь, бүгдийг сэргээх

¹⁰Харийнхан хана хэрмийг чинь босгон, тэдний хаад чамд үйлчилнэ. Чамайг Би хилэнгээрээ цохисон боловч, өршөөлөөрөө Би чамайг өрөвдөх болно. ¹¹Учир нь чиний дааман хаалганууд өдөр ч, шөнө ч хаагдахгүй, ямагт нээлттэй байж Хүмүүс үндэстнүүдийн эд баялгийг чамд авчирч хаад нь цувааг хөтөлж ирнэ. ¹²Чамд үйлчлэхгүй байх үндэстэн, хаанчлалууд сөнөнө. Тийм үндэстнүүд бүрмөсөн устгагдана.

¹³Миний ариун газрыг үзэсгэлэнтэй болгохын тулд Ливаны сүр жавхлан болох арц, жодоо, нарс мод чам уруу ирнэ. Би хөлийнхөө гишгүүрийг сүр жавхлантай болгоно. ¹⁴Чамайг зовоогчдын хөвгүүд нь ирж, чамд мэхийн, чамайг үзэн ядагчид бүгдээрээ хөлийн чинь уланд хүртэл бөхийнө. Тэд чамайг ЭЗЭНий хот буюу Израилийн Ариун Нэгэний Сион гэж нэрлэнэ. (Исаиа 60:10-14 АБ 2004)

⁴Тэгээд эртний балгаснуудыг сэргээн босгож, урьдын эвдэрсэн газруудыг янзалж, олон үеийн туршид хоосорч сүйрсэн хотуудыг шинэчлэн засварлана. ⁵Харь хүмүүс босож, та нарын сүргүүдийг хариулна. Харийн хөвгүүд та нарын тариаланч, усан үзэмчид болцгооно. ⁶Харин та нар ЭЗЭНий тахилч нар, бидний Бурханы үйлчлэгчид гэж нэрлэгдэн, үндэстнүүдийн эд баялгийг идэн, тэдний хөрөнгөөр сайрхах болно. ⁷Ичгүүрийнхээ оронд та нар хоёр дахин их хувийг авч, доромжлолын оронд тэд өөрсдийнхөө хувьд баярлан хашхирна.

Тийм учраас тэд өөрсдийн газартаа хоёр дахин ихийг эзэмшин, мөнхийн баяр баясгалан тэднийх болно. (Исаиа 61:4-7 АБ 2004)

¹Тэр өдөр чи ингэж хэлэх болно. “ЭЗЭН минь. Би Танд талархал өргөө. Та надад уурласан хэдий ч уураа татаж, намайг тайвшрууллаа. ²Үзэгтүн, Бурхан бол миний аврал. Би итгэн, айхгүй. ЭЗЭН БУРХАН бол миний хүч ба миний дуу, Тэр миний аврал болов” ³Тэгээд та нар авралын худгаас баяртайгаар ус татна. ⁴Тэр өдөр та нар ингэж хэлэх болно. “ЭЗЭНд талархлыг өргө, Түүний нэрийг дууд. Түүний үйлсийг хүмүүсийн дунд мэдэгд. Түүний нэр өргөмжлөгдсөнийг тэдэнд сануул. ⁵Гайхамшигт зүйлсийг хийсэн ЭЗЭНийг магтан дуул. Энэ бүхнийг газар дэлхий даяар мэдүүлэгтүн. ⁶Сионд суугчид аа! Чанга дуугаар баясан

хашхирагтун. Учир нь та нарын дунд байгаа аугаа нь Израилийн Ариун Нэгэн юм”. (Исаиа 12:1-6 АБ 2004)

²⁶Би танай шүүгчдийг анхных шиг нь, мөн зөвлөхүүдийг чинь эхнийх шиг нь сэргээнэ. Үүний дараа чи шударга хот, итгэлт хот гэж нэрлэгдэнэ”.

²⁷Сион үнэн шударгаар аврагдахад, Түүний гэмшсэн нэгэн зөвт байдлаар аврагдана. ²⁸Харин гэмт хэрэгтнүүд, нүгэлтнүүд хамтдаа бяцлагдан, ЭЗЭНийг умартагчдад төгсгөл ирнэ. ²⁹Та нар өөрсдийн хүссэн царснаас болж ичнэ. Та нар өөрсдийн сонгосон цэцэрлэгээс болж гутамшиг болно.

³⁰Учир нь та нар навчис нь хийсэх царс мэт, ямар ч усгүй цэцэрлэг мэт болно. ³¹Хүчтэн нь хуурайшсан мод болж, түүний үйлс нь оч болно. Тэд хоёул хамтдаа шатах бөгөөд түүнийг хэн ч унтраахгүй. (Исаиа 1:26-31 АБ 2004)

37.8.4 Газар

¹⁵Би тэднийг үндсээр нь тастасны дараа Би тэднийг дахин энэрнэ. Би тэднийг буцаагаад хүн нэг бүрийг өөрийнх нь өв уруу, өөрийнх нь нутаг уруу авчирна. (Иеремиа 12:15 АБ 2004)

²ЭЗЭН ингэж айлдаж байна. “Илднээс амьд үлдсэн хүмүүс цөлд нигүүлслийг олсон, амралтаа хайхаар явсан Израиль юм”. (Иеремиа 31:2 АБ 2004)

¹⁷Тэр тэдний төлөө шавга хаясан. Түүний мутар үүнийг тэдэнд хэмжээгээр нь хувааж өгсөн. Тэд энэ газрыг мөнхөд эзэмшиж, үеийн үед энд орших болно. (Иеремиа 34:17 АБ 2004)

¹⁴чи ЭЗЭНий дотор баяр хөөрийг авна. Би чамайг газрын өндөрлөгүүдээр аялуулан, эцэг Иаковын чинь өв хөрөнгөөр чамайг тэжээнэ” гэж ЭЗЭНий ам айлдсан юм. (Исаиа 58:14 АБ 2004)

⁷Бурхан Өөрийн ариун газарт айлдсан нь “Би ихэд баярлана, би Шекемийг хуваан, Суккотын хөндийг хэмжинэ. (Дуулал 108:7 АБ 2004)

⁸Шударга хүмүүс үүнийг хараад гайхаж, гэмгүй нэгэн өөрийгөө бурхангүй хүмүүсийн эсрэг болгоно. ⁹Гэсэн ч зөв шударга нэгэн өөрийн замаа хөөн явж, цэвэр гартай нэгэн улам хүчирхэг болон өсөх ажээ. ¹⁰Харин та бүгд одоо дахин ирээрэй. Учир нь та нарын дундаас мэргэн хүнийг би олохгүй байна. ¹¹Миний хоногууд өнгөрөн одож, миний төлөвлөгөөнүүд буюу зүрхний минь хүслүүд тасран үгүй болов. ¹²Тэд харанхуй орчинд “Гэрэл ойрхон байна” хэмээн шөнийг өдөр болгодог аж. ¹³Хэрэв би Үхэгсдийн орныг гэр шигээ харвал, би өөрийнхөө орыг харанхуйд засдаг болно. ¹⁴Хэрэв би нүхэнд хандан “Чи миний эцэг” гэж, өт хорхойд хандан “Миний эх болон миний эгч” гэж хэлдэг бол (Шастирын дээд 17:8-14 АБ 2004)

²⁸Миний та нарын өвөг дээдэст өгсөн газарт та нар амьдрах болно. Та нар Миний ард түмэн болж, Би та нарын Бурхан болно. (Езиекиел 36:28 АБ 2004)

⁷та нарын эцэг өвгөдөд үүрд мөнхөд Миний өгсөн нутагт буюу энэ газарт Би та нарыг оршин суулгана. (Иеремиа 7:7 АБ 2004)

¹⁵Би бас тэднийг өөрсдийнх нь газар дээр тарина. Миний тэдэнд өгсөн газраас тэд дахин үндсээрээ таслагдахгүй” гэж чиний Бурхан ЭЗЭН айлдаж байна. (Амос 9:15 АБ 2004)

37.8.5 Ургац

²³Дараа нь газарт тариалах та нарын үрслэгээнд зориулан Тэр бороо оруулна. Газрын ургац буюу хоол хүнс элбэг дэлбэг болно. Тэр өдөр та нарын мал сүрэг уудам бэлчээрт идээшилнэ. ²⁴Мөн газарт ажиллуулдаг шар, илжигнүүд утгуур ба ацаар шигшсэн давсалсан (Исаиа 30:23-24 АБ 2004)

37.8.6 Таалал

⁴⁰Тэдэнд сайныг үйлдэн, тэднээс эргэхгүй гэж Би тэдэнтэй үүрдийн гэрээ байгуулна. Тэд Надаас эргэхгүйн тулд Би тэдний зүрхэнд Надаас эмээхүйг хийнэ. (Иеремиа 32:40 АБ 2004)

³⁶Тийм учраас одоо Израилийн Бурхан ЭЗЭН “Энэ нь илд, өлсгөлөн болон тахлаар Вавилоны хааны гарт тушаагдсан” гэж чиний хэлж буй энэ хотын талаар ингэж айлдаж байна. ³⁷Үзэгтүн, Өөрийн уур, хилэн хийгээд их зэвүүцлээр тэднийг зайлуулсан бүх нутгаас Би тэднийг цуглуулна. Би тэднийг энэ газарт буцаан авчирч, тэднийг аюулгүй амьдруулна. ³⁸Тэд Миний ард түмэн, Би тэдний Бурхан болно. ³⁹Тэд өөрсдийн сайны төлөө болон өөрсдийн дараах үр хүүхдүүдийнхээ төлөө Надаас үргэлж эмээхийн тулд Би тэдэнд нэг зүрх, нэг замыг өгнө. ⁴⁰Тэдэнд сайныг үйлдэн, тэднээс эргэхгүй гэж Би тэдэнтэй үүрдийн гэрээ байгуулна. Тэд Надаас эргэхгүйн тулд Би тэдний зүрхэнд Надаас эмээхүйг хийнэ. ⁴¹Би тэдэнд сайныг үйлдэхээр тэдэнд баярлан баясаж, бүх зүрх болон бүх сэтгэлээрээ тэднийг энэ нутагт итгэлтэйгээр тарьж суулгана. ⁴²Учир нь ЭЗЭН ингэж айлдаж байна. “Би энэ ард түмэн дээр эдгээр бүх агуу гамшгуудыг авчирсантай адил түүнчлэн Би тэдэнд амлаж байгаа бүх сайныг Би тэдэн дээр авчрах гэж байна. ⁴³Чиний “Энэ нь хүн амьтангүй зэлүүд газар. Энэ нь халдеичуудын гарт тушаагджээ” гэж хэлж байгаа энэ нутагт талбайнууд худалдан авагдах болно. ⁴⁴Хүмүүс мөнгөөр талбайнуудыг худалдан авч, гарын үсгээ зурж, баримтуудаа битүүмжилж, Бениамины нутагт, Иерусалимын орчимд, Иудагийн хотуудад, уулархаг нутгийн хотуудад, нам дор газрын хотуудад болон Негевийн хотуудад гэрчүүдийг дуудна. Учир нь Би тэдний сайн сайхныг сэргээнэ” гэж ЭЗЭН тунхаглаж байна” гэв.тэжээл иднэ. (Иеремиа 32:36-44 АБ 2004)

15 Би түүнийг хоол хүнсээр элбэгээр ерөөнө. Би гачигдагсдыг нь талхаар хангана. 16 Түүний тахилч нарыг ч бас Би авралаар хувцаслах бөгөөд Түүний бурханлаг хүмүүс баярлан чангаар дуулна. 17 Тэнд Би Давидын эврийг ургуулна. Би Өөрийн тослогдогчийн төлөө дэнлүүг бэлтгэсэн юм. 18 Түүний дайснуудыг Би ичгүүрээр хувцаслана. Харин өөрийнх нь дээр титэм нь гялбах болно”. (Дуулал 132:15 - 18 АБ2004)

²⁶Би тэднийг болон Миний толгодын эргэн тойрон дахь газруудыг ерөөл болгоно. Цаг улиралд нь Би бороог оруулах болно. Тэр бол ерөөлийн бороо болох билээ. (Езекиел 34:26 АБ 2004)

¹²Би тэднийг ЭЗЭНий дотор тэнхрүүлж, Түүний нэр дотор тэд алхах болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Зехариа 10:12 АБ 2004)

⁶Би Иудагийн гэрийг тэнхрүүлж, Иосефын гэрийг аварна. Би тэднийг өрөвдсөн учир Би тэднийг буцаан авчирна. Би тэднийг голж байгаагүй мэт тэд байх болно. Учир нь Би бол тэдний Бурхан ЭЗЭН бөгөөд тэдэнд Би хариулах болно.

(Зехариа 10:6 АБ 2004)

¹⁰Учир нь ЭЗЭН та нарын дээр гүн нойрны сүнсийг цутгаж, та нарын нүд буюу эш үзүүлэгчдийг хааж, та нарын тэргүүн буюу үзмэрчдийг бүтээв. ¹¹Зөгнөл нь бүхэлдээ та нарын хувьд лацдуулсан номын үгс мэт болно. Тэд үүнийг номч хүнд өгч, “Үүнийг уншиж хайрла” гэхэд тэр “Би чадахгүй. Яагаад гэвэл энэ нь лацдуулсан” гэж өгүүлнэ. ¹²Дараа нь тэр номыг бичиг мэдэхгүй нэгэнд өгч, “Үүнийг уншиж хайрла” гэхэд тэр “Би уншиж мэдэхгүй” гэж хариулна.

¹⁷Өчүүхэн хугацааны дараа Ливан нь үржил шимтэй талбай болон хувирч, үржил шимтэй талбай нь ой хэмээн тооцогдоно. ¹⁸Тэр өдөр дүлий нь номын үгсийг сонсож, бүрэнхий харанхуйгаас сохруудын нүд нь харах болно. ¹⁹Даруу нэгний баяр хөөр ЭЗЭНий дотор өсөн нэмэгдэж, хүн төрөлхтний үгээгүйчүүд Израилийн Ариун Нэгэн дотор баясна. ²⁰Учир нь харгислагчдын төгсгөл ирж, элэглэгчид алга болж, бузар мууг үйлдэхийг санаархагч бүхэн таслагдана. ²¹Үгээр хүнийг буруутгагчид, дааман хаалган дээр шүүгч нэгнийг занганд оруулагчид, худал баримтаар зөвтнийг буруутан болгогчид таслагдана. ²²Ийм учраас Абрахамыг аварсан ЭЗЭН Иаковын гэрийн тухай айлдахдаа “Одоо Иаков ичихгүй, нүүр нь улайхгүй болов. ²³Харин Миний мутрын бүтээл болох хүүхдүүдээ тэр өөрийнхөө дотор харахдаа, тэд Миний нэрийг нандигнана. Үнэхээр тэд Иаковын Ариун Нэгэнийг нандигнан, Израилийн Бурханы аймшиг дотор зогсоно. ²⁴Сүнсээр төөрөгчид үнэнийг мэдэж, шүүмжлэгчид зааврыг хүлээн авна” гэв. 15 Би түүнийг хоол хүнсээр элбэгээр ерөөнө. Би гачигдагсдыг нь талхаар хангана. 16 Түүний тахилч нарыг ч бас Би авралаар хувцаслах бөгөөд Түүний бурханлаг хүмүүс баярлан чангаар дуулна. 17 Тэнд Би Давидын эврийг ургуулна. Би Өөрийн тослогдогчийн төлөө дэнлүүг бэлтгэсэн

юм. 18 Түүний дайснуудыг Би ичгүүрээр хувцаслана. Харин өөрийнх нь дээр титэм нь гялбах болно”. (Исаиа 29:17 - 24 АБ2004)

⁸Учир нь ЭЗЭН Би шударга ёсыг хайрлаж, хүчээр дээрэмдэхийг үзэн яддаг. Би тэдэнд шагналыг нь итгэмжтэйгээр өгнө. Би тэдэнтэй мөнхийн гэрээ байгуулна. ⁹Тэгэхэд үрс нь үндэстнүүдийн дотор, тэдний хойч үе нь хүмүүсийн дунд танигдана. Тэд бол ЭЗЭНий ерөөсөн үрс байна гэж тэднийг харсан бүгд мэдэх болно. (Исаиа 61:8 - 9 АБ2004)

37.8.7 Сүй тавьсан

¹⁹Би чамтай мөнхөд сүй тавина.Тийм ээ, Би зөвт байдал, шударга ёс, хайр энэрэл, өршөөлөөр чамтай сүй тавина. ²⁰Би чамтай итгэмжит байдал дотор сүй тавина.Тэгээд чи ЭЗЭНийг мэдэх болно. ²¹Тэр өдөрт Би хариу өгөх болно” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Би тэнгэрүүдэд хариу өгч, тэдгээр нь газарт хариу өгнө. (Хосеа 2:19 - 21 АБ2004)

¹⁹Өрнө зүгт хүмүүс ЭЗЭНий нэрээс эмээн, наран ургах зүгт тэд Түүний алдраас айна. Дайсан голын урсгал мэт ирвэл ЭЗЭНий салхи түүнийг хөөж явуулна. (Исаиа 59:19 АБ2004)

37.8.8 Мөнхийн баяр баясгалан , Хефзиба Бьюла

⁸Тэнд нэгэн их зам харгуй буй болж, Ариун Их Зам гэж нэрлэгдэнэ. Түүгээр бузар нь явахгүй, тэнэг хүмүүс түүгээр алхсан ч тэд замаасаа үл төөрнө. ⁹Тэнд нэг ч арслан алга, ямар ч махчин араатан гарч ирэхгүй. Тэнд тэд олдохгүй. Харин солигдогсод л түүгээр алхана. ¹⁰ЭЗЭНий золин авсан хүмүүс буцаж, баяр хөөртэй хашхиралдан Сион уруу ирнэ. Тэдний толгой дээр үүрдийн баясгалан байна. Уй гашуу, санаа алдалт зугтан одож, тэд баяр баясгалан, аз жаргалыг олно. (Исаиа 35:8 - 10 АБ2004)

¹Тэр өдөр Иудагийн нутагт энэ дуу дуулагдана. “Бидэнд хүчирхэг хот байна. Авралд зориулан Тэрээр хэрэм, бэхлэлт босгосон.

²Дааман хаалгаа нээн, итгэмжит байдлыг сахигч нэгэнийг болон шударга зөв үндэстнийг оруул. ³Танд итгэдэг учраас

бодол санаагаар бат зогсогч хүнийг Та төгс амар тайван дотор хамгаална. ⁴Үүрд ЭЗЭНд итгэгтүн. Учир нь ЭЗЭН БУРХАН дотор мөнхийн Хад бий. ⁵Өндөрт залрагчдыг Тэрээр номхтгож, халдашгүй хотыг доройтуулан, газарт унаган шороонд шиднэ. ⁶Түүнийг зүдрэгсэд, ядуусын хөл гишгэлж дэвсэлнэ”. (Исаиа 26:1 - 6 АБ2004)

¹⁹Иерусалимд оршин суугч Сионы хүмүүс ээ! Та нар цаашид уйлахгүй. Та нарын уйлах дуунаар Тэр та нарт нигүүлсэнгүй байх болно. Тэр үүнийг сонсмогцоо та нарт хариу өгнө. ²⁰Хэдийгээр Эзэн та нарт эмгэнэлийн талх, тарчлалын ус өгсөн боловч, та нарын Багш цаашид Өөрийгөө нуухгүй бөгөөд харин та нар нүдээрээ Багшийгаа үзнэ. ²¹Та нар баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, ард чинь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэсэн үгийг та нарын чих сонсоно. ²²Та нар мөнгөөр бүрсэн өөрсдийн сийлмэл хөргүүд, алтаар бүрсэн өөрсдийн цутгамал хөргүүдийг бузарлан, тэдгээрийг бузар эд зүйл мэт тарааж хаяад “Зайлагтун” гэж хэлнэ. (Исаиа 30:19 - 22 АБ2004)

¹Үнэн зөв нь гэрэл гэгээ мэт, аврал нь шатаж буй бамбар мэт ирэх хүртэл Сионы төлөө Би дуугүй байхгүй, Иерусалимын төлөө Би чимээгүй байхгүй. ²Үндэстнүүд чиний үнэн зөвийг, бүх хаад чиний алдрыг үзнэ. ЭЗЭНий ам хайрласан шинэ нэрээр чамайг нэрлэнэ. ³Чи ЭЗЭНий мутар дахь үзэсгэлэнт титэм, өөрийн Бурханы мутар дахь цэцгэн хэлхээ болно. ⁴Үүнээс хойш чамайг “Мартагдсан” хэмээн, чиний газрыг “Эзгүй зэлүүд” гэж хэлэхгүй. Харин чамайг “Түүний доторх Миний баяр хөөр” гээд, чиний газрыг “Гэрлэсэн” гэж нэрлэнэ. Учир нь ЭЗЭН чамд баярлан, чиний газар гэрлэх болно. ⁵Учир нь залуу хүн онгон охинтой гэрлэдэг шиг чиний хөвгүүд чамтай гэрлэнэ. Сүйт залуу сүйт бүсгүйдээ баярладаг шиг чиний Бурхан чамд баярлана. (Исаиа 62:1 - 5 АБ2004)